ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2023 оны жилийн эцсийн байдлаар

2023.12.08 СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭС

| Шийдвэр д/д | Заалт д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Өөрийн үнэлгээ | Дээд байгуул-лагын үнэлгээ | Үнэлгээ-ний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| Монгол улсын хууль | | | | | | | |
| 1 | 1 | Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017.12.07 Дугаар 2019.01.01 | 55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | Тус хэлтэс нь Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөр, “Сургалт хөгжил” –ийн хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж байна. 2023 оны байдлаар Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр 70 %, “ Сургалт хөгжил ” –ийн хөтөлбөрийн хэрэгжилт 90 % хэрэгжсэн байна | 80 % | | |
| 2 | 2 | Ерөнхий боловсролын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай 2019—05-30 Дугаар 2019.05.30 | 10.2.2 Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу боловсруулж батлуулах | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний стандарт шинэчлэгдсэн боловсруулагдаж байгаа төслийг Орхон аймгийн ХХААГ, МХГ, БШУГ, ГБЗХГ, ХХААГ, ЕБСургуулиуд болон цэцэрлэг зэрэг нийт 37 байгууллага руу хүргүүлсэн бөгөөд 8 байгууллагаас 18 санал ирүүлснийг нэгтгэн СХЗГазарт хүргүүлсэн.<br>Дахин боловсруулсан төслийг хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандартчиллын техникийн хорооны хурлаар 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр дахин хэлэлцэж дэмжигдэн стандарт батлагдан хэрэгжиж байна | 100% | | |
| 3 | 3 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар: 2022.05.01 | 8.2.1. Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн | Байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, баримтлах зарчим, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, итгэмжлэлийн болон чанарын удирдлагын тогтолцооны гэрчилгээ, тэргүүлэх чиглэлийг байгууллагын хонгилд самбараар ил тод байршуулсаны зэрэгцээ үйл ажиллагааны стратегийн | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зорилтыг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна.<br>Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны чиглэл, зорилго зэргийг www.masm.gov.mn, Орхон аймгийн төрийн байгууллагуудын www.erdenet.mn, цахим хуудас болон мэдээллийн самбартаа байрлуулан, шаардлагатай тохиолдолд шинэчлэн ажиллаж байна.<br>2022 оноос цахим мэдээллийн хуудсыг нэг ажилтанд хариуцуулан өгч, байвал зохих мэдээллүүдийг бүрэн оруулах үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангаснаар www.masm.gov.mn цахим хуудсанд 5 чиглэлээр 25 төрлийн мэдээг холбогдох нэгж тус бүр байршуулж байна. | 100% | | |
| | 4 | | 8.2.2. Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг | Сургалт мэдээлэл, салбар сан, Баталгаажуулалтын алба, Хэмжил зүйн нэгдсэн лаборатори, Захиргаа, Аж ахуй , Хими нян судлалын лаборатори гэсэн бүтэцтэй, нийт 21 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна.<br>Хаяг: Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уурхайчин, ДГТ-3 Стандарт, Хэмжил зүйн хэлтэс<br>Утасны дугаар: 70350552<br>Имайл хаяг: Orkhon@masm.gov.mn<br>Веб хаяг: https://masm.gov.mn/orh/<br>Facebook page хаяг: Орхон Стандарт Хэмжил зүйн Хэлтэс зэрэг мэдээллээ салбарын мдээлийн цахим хуудас болох www.masm.gov.mn болон орон нутгийн төрийн байгууллагын цахим хуудас болох www.erdenet.mn -д байршуулсан бөгөөд гарын авлага, тараах материал болон сургалтын лекц ррт-д байнга байршуулж мэдээллэн ажиллаж байна. | 100% | | |
| | 5 | | 8.2.3. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын | Орхон аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, байгууллагын үйл ажиллагааны стратеги зорилтууд болон гүйцэтгэлийн тайланг тус аймгийн www.erdenet.mn цахим хуудсанд байрших е-оффисс системд байршуулж хэвшсэн. Хэлтсийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж | үнэлгээний тухай мэдээллийг нийт ажилтнуудад танилцуулан, цаашид анхаарах асуудлаар төлөвлөн хэрэгжүүлдэг.<br>Хэлтсийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит , санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан, санхүүгийн аудитийн дүгнэлтийг хэлтсийн “Төсөв санхүүгийн ил тод байдал” самбараар болон www.masm.gov.mn цахим хуудсанд байршуулсан | | | |
| | 6 | | 8.2.4. Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан | Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг хагас бүтэн жилээр гаргаж е-оффис системд байршуулж байна. | 100% | | |
| | 7 | | 8.2.5. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг аймгийн ХБТХОХэлтэс болон холбогдох байгууллагуудад илгээж, тус аймгийн www.erdenet.mn цахим хуудсанд байрших е-оффисс системд байршуулж хэвшсэн. | 100% | | |
| | 8 | | 8.2.6. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт | Үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байгаа Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Хэмжил зүйн тухай хуулийн нийтлэг зүйл заалтуудыг самбараар ил тод байршуулан нийтэд мэдээлж, Засгийн газрын шийдвэр бусад эрх зүйн актыг тараах материал, гарын авлагаар түгээж байна. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг е-оффисс системд байршуулж хэвшсэн.<br>Мөн www.masm.gov.mn цахим хуудсанд байрших Орхон аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс хэсэгт болон тус аймгийн www.erdenet.mn цахим хуудсанд байрших Стандарт, хэмжил зүйн хэлтэс хэсэгт байршуулсан. | 100% | | |
| | 9 | | 8.2.7. Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг/эх/ -ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудан хаяг | СХЗГ-ын даргын 2023 оны 02-р сарын 27-ны өдрийн А/36 дугаар тушаалаар аймаг дахь СХЗХ-ийн албан тушаалын ангилал, зэрэглэл, дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарт нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | өдрийн А/89 дүгээр тушаалаар албан тушаалын тодорхойлолтыг баталж, Төрийн албаны зөвлөлөөр 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр хянуулж, батлуулсныг хэрэгжүүлэн ажиллаж байна. ТҮ-ний албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг хэлтсийн даргын 2020 оны 06-р сарын 23-ний өдрийн А/10 дугаар тушаалаар батлан, мөрдөж байгаа бөгөөд чиг үүрэгт өөрчлөлт ороогүй байна. Албан тушаалын тодорхойлолт албан тушаалтны эцэг/эх/ -ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаарыг www.erdenet.mn цахим хуудсанд оруулсан.<br>Мөн албаны цахим шуудангийн хаягийг СХЗГ-ын мэдээлэл хариуцсан ажилтанд албан бичиг явуулж хүсэлт өгсөний дагуу албан хаагчид албаны masm.gov.mn хаягтай болсон.<br>Энэ мэдээллийг www.masm.gov.mn болон орон нутгийн төрийн байгууллагын цахим хуудас болох www.erdenet.mn -д байршуулсан | | | |
| | 10 | | 8.2.8. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ | Санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас буюу хайрцаг /дэвтэр/ ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлснээр өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариуг өгч хэвшсэн байна. Өргөдөл гомдлын тайлан мэдээг www.erdenet.mn цахим хуудсанд байрших өргөдөл гомдол системд мэдээлж байна. Тус онд цахимаар болон цаасаар ирсэн ямар нэг өргөдөл, гомдол байсангүй.<br>Хүний нөөцийн удирдлага, төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гомдол саналыг хүлээн авах **“Албан хаагчийн ёс зүй”** буланг хэрэглэгчдэд ил тод байршуулсан. ажиллуулж байна. Ажилтнуудтай холбоотой мэдээлэл ирээгүй байна. | 100% | | |
| | 11 | | 8.2.9. Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл | Улирал бүр статистик мэдээний нэгтгэлийг хэлтсийн үйл ажиллагааны чиглэл бүрээр гаргаж www.masm.gov.mn сайтад байршуулж хэвшсэн.<br>Тохирлын гэрчилгээ эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг агуулсан мэдээллийг www.masm.gov.mn цахим хуудсанд байрших | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | “Баталгаажуулалтын мэдээллийн нэгдсэн сан” -д тухай бүр оруулан нийтэд ил тод мэдээлж байна. Хэмжил зүйн статистик мэдээг сар бүр, Стандартын статистик мэдээг улиралд нэг удаа маягтын дагуу СХЗГ-т илгээснээр мэдээлэл нэгтгэгдэж хэмжилзүйн мэдээллийн нэгдсэн санд орж нийтэд ил тод мэдээлэгдэж байна. | | | |
| | 12 | | 8.2.10. Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр | Стандартын салбар сан хариуцсан ажилтанд мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг хариуцуулан зохион байгуулж байгаа олон нийтийн арга хэмжээний хөтөлбөрийг цахим болон цаасан хэлбэрээр төр болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд зарлан мэдээллэж ажиллаж байна. | 100% | | |
| | 13 | | 8.3.1. Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл | СХЗГ-ын даргын 2023 оны 02-р сарын 27-ны өдрийн А/36 дугаар тушаалаар аймаг дахь СХЗХ-ийн албан тушаалын ангилал, зэрэглэл, дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарт нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан гарсан сул орон тоог бүртгэж, шаардлагатай байгаа орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь салбар зөвлөлд мэдээллэн хүргүүлсэн бөгөөд www.masm.gov.mn цахим хуудсанд болон хэлтсийн Орхон Стандарт Хэмжил зүйн Хэлтэс Facebook хуудсаар нийтэд мэдээлсэн. | 100% | | |
| | 14 | | 8.3.2. Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам | Сул орон тоог Төрийн албаны тухай хуулийн 26.1, 26.3, 27.1,2 дахь заалтууд болон Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам " - ын 8.2.1-д заасныг тус тус үндэслэн томилгоог хийж, тус заалтын дагуу нөхөх боломжгүй тохиолдолд захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь салбар зөвлөлд сул орон тооны мэдээллийг хүргүүлэхийг зэрэгцээ www.masm.gov.mn цахим хуудсанд болон хэлтсийн Орхон Стандарт Хэмжил зүйн Хэлтэс Facebook хуудсаар нийтэд мэдээлсэн. | 100% | | |
| | 15 | | 8.3.3.Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм | Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны болон Төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | болон СХЗГ-ын даргын 2022 оны 04-р сарын 22-ний өдрийн А/82 дугаар тушаалаар батлагдсан Стандарт хэмжил зүйн салбарын үйл ажиллагаа болон албан хаагчдад тавих шаардлага CS11-0182:2022 байгууллагын стандартыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, байгууллагын ил тод байдлын самбарт болон цахим мэдээллийн хуудсанд байршуулсан. | 100% | | |
| | 16 | | 8.3.4.Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам | Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам боловсруулан, байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил тод, нээлттэй байдлыг хангах арга замыг хүний нөөцийн стратегид тусган хэрэгжүүлж байна. Хүний нөөцийн чиглэлээр өөрийн байгууллагын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, түүнд тулгуурлан хүний нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулахад анхаарч, ажлын шаардлага, мэдлэг ур чадварын түвшинг харгалзан хүний нөөцийг оновчтой зөв байршуулах дээр анхаарч байна. | 100% | | |
| | 17 | | 8.3.5.Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ | Салбарын хэмжээнд мөрдөх Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгүүд (Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр)-ийг цахим мэдээллийн хуудсанд байршсан. Хүний нөөцийн мэдээллийн тогтолцоог бий болгох, мэдээллийг хүний нөөцийн хөгжлийг удирдах хэрэгсэл болгох, онцгой ур чадвартай нарийн мэргэшсэн хүнийг шаардлагатай ажлын байранд байршуулах, ажилд авах, албан тушаал дэвшүүлэх, холбогдох бусад шиидвэрийг хүний нөөцийн мэдээлэлд үндэслэн гаргах үйл явцыг удирдлагын түвшинд хэвшүүлэхээр сул торон тооны зар зэргийг цахим хуудас болон ил тод байдлын самбарт байршуулан ажиллаж байна. | 100% | | |
| | 18 | | 8.3.6.Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлэх журам | Хүний нөөцийг үнэлж дүгнэхдээ Засгийн газраас баталсан " Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам" - ыг мөрдөн ажиллаж байна. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр байгууллагын дотоод журамд тодорхой тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд төрийн албан хаагчдын гүйцэтгэлийг үнэлэх журмын дагуу хагас бүтэн жилээр ХШҮ хариуцсан ажилтан, хэлтсийн даргатай хамтарсан үнэлгээг хийж, үнэлгээг и-оффис системд нэгтгэн оруулж, ЗДТГ-ын ХШҮ хариуцсан ажилтнаар хянуулж ажиллалаа. | | | |
| | 19 | | 8.4.1.Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл | 2022 оны төсвийн гүйцэтгэл -232092,9 мянган төгрөг, 2023 онд батлагдсан төсөв – 495394.5 мянган төгрөг, 2024 оны төсвийн төсөл -794397,6 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансанд, www.masm.gov.mn цахим хуудсанд болон төсвийн ил тод байдлын самбарт тус тус байршуулсан. | 100% | | |
| | 20 | | 8.4.2.Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас бүтэн жилийн санхүүгийн тайлан | 2023 оны байдлаар 495394.5 мянган төгрөгийн цалин хөлс болон бусад зардлын батлагдсан төсөв. 495274,0 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны гүйцэтгэл мэдээллийг сар бүр шилэн дансанд, www.masm.gov.mn цахим хуудсанд болон төсвийн ил тод байдлын самбарт байршуулсан. | 100% | | |
| | 21 | | 8.4.3.Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт | 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт авсныг шилэн дансанд, www.masm.gov.mn цахим хуудсанд болон төсвийн ил тод байдлын самбарт байршуулсан. 2023 оны тайлангийн аудит хийгдээгүй байна. | 100% | | |
| | 22 | | 8.4.4.Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ | Бүтээгдэхүүн, үйлчилгээний, Стандартын , Хэмжилзүйн баталгаажуулалтын үнэ тариф, 2023 оны орлогын төлөвлөгөө 125000,0 мянган төгрөг, гүйцэтгэл 196666,8 мянган төгрөг буюу 157,3 % биелэсэн гүйцэтгэлийн мэдээг www.masm.gov.mn цахим хуудсанд болон төсвийн ил тод байдлын самбарт байршуулсан. | 100% | | |
| | 23 | | 8.4.5.Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар | Төсвийн хэтрэлт байхгүйг мэдээлсэн | 100% | | |
| | 24 | | 8.4.6.Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг | 2023 онд Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ байхгүйг шилэн дансанд мэдээлсэн | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 25 | | 8.4.7.Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт | Лабораторийн ажлын байрны түрээсийн төлбөр 5284,9 мянган төгрөгийг Орон нутгийн өмчийн газарт, лабораторийн шинжилгээний төлөвлөгөөт орлого 25000,0 мянган төгрөгийг СХЗГ-т шилжүүлснийг Шилэн дансны хуулийн дагуу холбогдох хугацаанд нь мэдээгээ байршуулсан. | 100% | | |
| | 26 | | 8.4.8.Бонд, зээл, өрийн бичиг , баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр | Бонд, зээл, өрийн бичиг , баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр гаргаагүй болно | - | | |
| | 27 | | 8.4.9.Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл | 2022 онд Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас шилэн дансны хөтлөлт хэрэгжилтэнд 90 %-тай дүгнэгдсэн. Энэ онд Шилэн дансны хуулийн дагуу холбогдох хугацаанд нь мэдээгээ байршуулж байна. | 100% | | |
| | 28 | | 8.4.10.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн бичиг баримт, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа явагдаагүй | - | | |
| | 29 | | 8.4.11.Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт | - | | | |
| | 30 | | 8.4.12.Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл | - | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 31 | | 8.4.26.Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн | - | | | |
| | 32 | | 8.4.27.Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан | - | | | |
| | 33 | | 8.4.28.Хууль тогтоомжид заасан бусад | - | | | |
| | 34 | | 8.5.1.Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл | “Хэмжил зүйн ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” Монгол улсын шадар сайдын 2015 оны 11 дугаар сарын 06-ны өдрийн 117 дугаар тушаалын дагуу хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын ажлыг, “Стандартын үнэ, ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох тухай” Стандартчилал, хэмжил зүйн газрын даргын 2015 оны 03 сарын 13-ны өдрийн А/64 тоот тушаалын дагуу стандарт, мэдээлэл лавлагаа, “Баталгаажуулалтын ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг батлах тухай” Монгол улсын шадар сайдын 2019 оны 03 сарын 27-ны өдрийн 22 дугаар тушаалын дагуу баталгаажуулалтын ажлыг тус тус гүйцэтгэж байна.<br>Үндсэн үйл ажиллагааны данс: 100210009001<br>Туслах үйл ажиллагааны данс: 100210009002 зэрэг мэдээллийг цахим болон цаасан хэлбэрээр мэдээлж байна. | 100% | | |
| | 35 | | 8.5.2.Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа | Тус хэлтэс нь тусгай зөвшөөрөл олгодоггүй, харин стандартын хэрэгжилт хангаж байгаад тохирлын үнэлгээ хийж, тохирсны нотолгоо болох тохирлын гэрчилгээг олгодог ба олгож байгаа тохирлын гэрчилгээний мэдээллийг сар бүр цахим хэлбэрээр нийтэд сурталчилан таниулж, түүнийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмын мэдээллийг цахимаар болон самбарт, угтах үйлчилгээний хэсэгт ил тод байршуулан ажиллаж байна.<br>Тухайн хугацаанд авсан тохирлын гэрчилгээ эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | болон дуусгавар болох хугацааг агуулсан мэдээллийг www.masm.gov.mn цахим хуудсанд байрших “Баталгаажуулалтын мэдээллийн нэгдсэн сан” -д бүртгэж байна. Түүнчлэн АЗДТГазрын И-оффисс цахим хуудас, салбарын болон хэлтсийн facebook хуудсандаа тухай бүр байршуулж байна. | | | |
| | 36 | | 8.6.1.Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал | “Стандарт ба хэмжил зүйн талаар төрөөс баримтлах бодлого”, “ Стандарт ба хөгжил” үндэсний хөтөлбөрийн төслийг танилцуулан, хэлэлцүүлгийг зохион байгуулахаар 8 заалт бүхий ажлын төлөвлөгөө гарган<br>Монгол улсын Алсын хараа - 2050, Шинэ сэргэлтийн бодлоготой уялдуулан Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлого, хэрэгжилтийг олон улсын түвшинд хүргэх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор боловсруулсан “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн төсөл” / нэмэлт өөрчлөлт/, Төрөөс стандартчилал, хэмжил зүйн талаар баримтлах бодлогын төсөл, “Стандарт ба хөгжил” үндэсний хөтөлбөрийн төслийг танилцуулах, хэлэлцүүлэх, санал авах ажлыг сонирхогч талууд буюу Орхон аймгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийн төлөөллүүд, баталгаажуулалтын зөвлөл, Баян-Өндөр сум болон Жаргалант сумын багийн зохион байгуулагч нарыг хамруулан 3 удаа зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Уул уурхай, эрчим хүчний салбарын , хөнгөн болон хүнсний үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудыг оролцуулан нийт 61 байгууллагын 71 төлөөлөл оролцож саналаа солилцсон байна. Төрийн 83 байгууллагад төслийг хүргүүлснээр 5 байгууллагаас саналыг хүлээн авч нийт 118 байгууллагыг оролцуулан 19 саналыг авч нэгтгэн удирдах дээд байгууллагадаа хүргүүлсэн. Шинэ болон шинэчлэн боловсруулах стандартын төсөлд санал авах ажилд орон нутгийн байгууллагуудыг татан оролцуулах чиглэлээр тогтмол мэдээлэл өгч ажиллаж байна | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 37 | | 8.6.2.Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт | Байхгүй | - | | |
| | 38 | | 8.6.3.Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл | Хамааралгүй | - | | |
| | 39 | | 8.6.4.Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл | Хамааралгүй | - | | |
| | 40 | | 8.6.5.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг | Хэлтсийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, татварын тайланг холбогдох хуулийн хугацаанд нь гаргаж баталгажуулан илгээж байна. | 100% | | |
| | 41 | | 8.6.6.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/ -ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавих шаардлага, удирдлагын сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл | Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлагын нэгдсэн тогтолцооны системд албан хаагчдын мэдээллийг бүрэн оруулж, шинэчлэлт хийж ажиллав. 19 албан хаагчийн албаны цахим шуудангийн хаягийг оруулж өгснөөр авч байгаа цалин урамшууллын мэдээллийг тогтмол авч байна. Тайлант хугацаанд тус хэлтсийн дэргэдэх орон тооны бус баталгаажуулалтын зөвлөлийн бүрэлдэхүүн, хэлтсийн удирдах ажилтанд тавих шаардлага,холбогдох мэдээллийг цахим хуудсандаа байршууллаа. Тус хэлтэст удирдлагын сонгон шалгаруулалт зарлах, оролцох шаардлага гараагүй болно. | 100% | | |
| | 42 | | 8.6.8.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, | Тайлант онд төсвийн хөрөнгийг ашиглалтаас гаргасан тохиолдол байхгүй. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл | | | | |
| | 43 | | 8.6.10.Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл | Тус хэлтсийн үйл ажиллагаа болон хэрэглэж буй тоног төхөөрөмж нь хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй болно. Байгууллагын албан хаагчдад дахивар хог хаягдал хаях хогийн сав шийдэж мөн зай болон бусад хог хаягдлыг ил задгай хаяхын хор уршгийг суртчилан таниулж, хэлтсээс гарч байгаа хог хаягдлаа “Хог хаягдлын менежментийг сайжруулах” ажлын төлөвлөгөөний дагуу цуглуулж /цаасан, дахивар, зай, принтерийн хор, бусад хог хаягдал гэх мэт/ ангилан, хаяж байна. Цуглуулсан дахивар хог хаягдлыг дахин боловсруулах газар болон тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгч байна. Энэ талаар мэдээллээ www.masm.gov.mn -д мэдээлсэн. | 100% | | |
| | 44 | | 8.6.11.Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт | Орон нутгийн өмчийн газартай түрээсийн гэрээ байгуулан ажилладаг, шинээр барилга байгууламж бариагүй. | - | | |
| | 45 | | 8.6.20.Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл | www.masm.gov.mn цахим хуудсанд байрших “Баталгаажуулалтын мэдээллийн нэгдсэн сан” -д тус аймагт баталгаажуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээллийг нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоохгүйгээр нээлттэй өгөгдөл болгон ашиглуулахаар байршуулж байна.<br>Стандартын мэдээллийн нэгдсэн сан, стандартын төсөлд санал авах мэдээллийг иргэд хэрэглэгчдэд танилцуулах ажлыг сургалт сурталчилгаа бүрд хийж байна.<br>Хэмжилзүйн мэдээллийн нэгдсэн санд оруулах мэдээллийг сар бүр СХЗГазарт хүргүүлж байна.<br>Эдгээр мэдээллийн санг E-mongolia цахим системд холбох ажил хийгдэж байна.<br>Хэлтсийн санхүүгийн үйл ажиллагааг www.masm.gov.mn – д байрших шилэн данс хэсэгт байршуулан мэдээлж байна | 100% | | |
| | 46 | | 8.6.21.Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/ -ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, | Байгууллагын зардлаар суралцаж байгаа хүн байхгүй | - | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт | | | | |
| | 47 | | 8.6.22.Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл | Шилэн дансны мэдээлэл зэрэг холбогдох мэдээллүүд байршсан | 100% | | |
| **Хэсгийн дундаж: 99,4 хувь** | | | | | | | |
| Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол | | | | | | | |
| 4 | **48** | **1-5-р зүйл** | Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай<br><br>2012 оны 04 дугаар сарын 25-ны өдөр | Журмын хэрэгжилтийг бүрэн хангаж байгууллагын төлөвлөгөөнд болон авлигын эсрэг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүллээ. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /2021-2023/ -ийн 5 зорилтод тусгасан 20 арга хэмжээг 97,9% хэрэгжүүлж , тайлагнасан байна.<br>Авлигатай тэмцэх газраас болон АЗДТГазраас шаардсан мэдүүлэг, бусад баримт бичгийг хугацаанд нь хүргүүлж ажиллав.<br>Авлига, ашиг сонирхлын зөрчил, хууль зөрчсөн асуудал гарсангүй.<br>Авилгын эсрэг сургалтанд албан хаагчдийг хамруулсан. АЗДТГазраас ирүүлсэн сурталчилгааны материалуудыг нийтэд цахимаар болон цаасан хэлбэрээр түгээж , сурталчилсан. | 100 % | | |
| **Хэсгийн дундаж: 100,0 хувь** | | | | | | | |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | | |
| 5 | 49 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх тухай<br>2018-05-23<br>Дугаар 2018-46 | 3.Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж,гудамж талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлэг тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах,<br>Үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачлагыг хөхүүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, | Хэлтсийн гадна хаяг болон дотор өрөө тасалгаануудын хаягийг кирилл болон монгол бичгээр хослуулан бичүүлж хийлгэсэн.<br>2023 оны жилийн эхэнд монгол бичиг сурах сургалтын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллалаа. Үүний үр дүнд 11 ажилтан анхан шатны мэдлэгтэй, 8 ажилтан дунд шатны мэдлэгтэй болсон.<br>Орхон аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан Монгол бичгээр албан бичиг хөтлөх сургалтад 4 албан хаагч сургалтад хамрагдаж, нийт албан хаагчдаа мэдлэгээ хуваалцсан. | 90% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | | | | |
| 6 | 50 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43 | 1.4 Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүр мөсөн хориглосон. | Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйл согтууруулах ундаа хэрэглэх, худалдах, түүгээр үйлчлэхэд хориглох зүйл заалтуудыг ажилтнуудад танилцуулан мэдэгдэх хуудас гарган гарын үсэг зуруулаа.<br>Тус онд албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалт зохион байгуулаагүй болно. | 100% | | |
| | 51 | | Нийт иргэн, аж ахуйн нэгж, байгууллага архи согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл, мэнд нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачлагатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалах | Архидан согтуурахтай тэмцэх, тухай хуулийн хэрэгжилтийг хангах урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний дагуу нийт ажилтан албан хаагч нарт “Мансууруулах бодис түүний хор уршиг” сэдвээр танилцуулга бэлтгэж мэдээлэл хүргэж, өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриаллаа.<br>Орхон аймагт үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байгаа 208 хүнсний үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйл согтууруулах ундаа хэрэглэх, худалдах, түүгээр үйлчлэхэд хориглох зүйл заалтуудыг мэдээллийн самбарт тавих, нийтэд сурталчилахыг зөвлөсөн байна.<br>Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан Электрон тамхины хор нөлөө сэдэвт сургалтад 5 ажилтан хамруулсан. | 100% | | |
| **Хэсгийн дундаж: 96,7 хувь** | | | | | | | |
| Засгийн газрын тогтоол | | | | | | | |
| | 52 | Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018.08.22 Дугаар 2018-258 | 1.2. Иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 9 | Иргэд , хэрэглэгчдэд мэдээ мэдээллийг тогтмол хүргэх хуваарь гаргаж, чиглэл тус бүрээр мэдээллийг ил тод өгч ажилласнаар 2023 онд ямар нэг өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирээгүй байна. Аймгийн төрийн байгууллагуудын И-Оффис нэгдсэн программд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг тогтмол авч ажиллаж байгаа боловч тус хэлтсийн үйл | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | | | дүгээр сарын 1-ний өдөрт багтаан шийдвэрлэж, , хариуг өгөх, цаашид өргөдөл гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх | ажиллагаатай холбоотой өргөдөл гомдол ирээгүй болно. | | | |
| | 53 | | 1.4. Төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн ажлыг бэхжүүлэх | 2023 онд гарсан сул орон тоог журмын дагуу мэдээлж ажилласан.<br>Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам, шатлан дэвшүүлэх зарчмын дагуу байгууллагын доторх албан хаагчаас 1 албан хаагчийг томилон , нөөцөөс 1 сул орон тоог нөхөж авахаар зарлуулаад байна. Тухайлбал: Сорьцын хяналтын улсын байцаагч бөгөөд Ахлах мэргэжилтний сул орон тоонд тус хэлтсийн Бүтээгдэхүүн баталгаажуулалтын мэргэжилтнийг томилон ажиллуулж , бүтээгдэхүүн баталгаажуулалтын мэргэжилтний сул орон тоон дээр тусгай шалгалт зарлуулж, нөөцөд бүртгэлтэй 1 хүнээр нөхөж, Хэмжил зүйн хяналтын улсын байцаагчийн албан тушаалын сул орон тоог нийт 4 удаа захиалгыг Орхон аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд материалыг хүргүүлсний зэрэгцээ төрийн албан хаагчдаас шилжүүлэн болон сэлгэн ажиллуулахаар зарыг мэдээллийн хэрэгслээр байршуулж, 2 иргэний материалыг хүлээн авсан боловч сул орон тоон дээр туршлагын шаардлага болон албан тушаалын тодорхойлолтод заасан албан тушаалын ангилалын индекс таараагүй тул нийтэд нээлттэй 2 удаа зарласан боловч шаардлага хангасан хүн орж ирээгүй байна. | 90% | | |
| | 54 | | 1.5. Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалд албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа удирдах албан тушаалтнуудын сонгон шалгаруулалтын захиалгыг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, сонгон | Түр орлон гүйцэтгэгч байхгүй болно. | - | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шалгаруулалтын дагуу удирдах албан тушаалтныг томилох | | | | |
